

**Үндсэн хууль дахь хүрээлэн байгаа  
орчны эрхийн баталгаа, түүний онцлог**

**Guarantees of Environmental Rights in the  
Constitution and Their Characteristics**

Сүхбаатарын Сүхчулуун

*Хууль зүйн ухааны доктор (LL.D.).*

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн  
Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш*

*Улаанбаатар хот, Монгол Улс*

*sukhchuluun.s@num.edu.mn*



**[Товч утга]**

Энэхүү өгүүлэлд 1992 оны 1 дүгээр сарын 13-ны батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг бүрдүүлсэн холбогдох зүйл заалтыг тодруулах, улмаар тус эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан онцлогийн талаар дэлгэрүүлэн авч үзэх болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг бүрдүүлэхдээ 1) иргэний үндсэн эрх; 2) иргэний журамт үүрэг; 3) төрийн хүлээх үүрэг гэсэн гурван талаас нь хуульчилсан онцлогтой болохыг энэхүү илтгэлд өгүүлсэн болно. Мөн хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг бүрдүүлэхдээ хүрээлэн байгаа орчны эрхийг процессын шинжтэй эрх болох талаас нь баталгааг бүрдүүлэх тухай үзэл санаа 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн онцлогтой.

**[Түлхүүр үг]**

Хүрээлэн байгаа орчин, байгаль орчин, эрүүл, аюулгүй орчин.

## I. Оршил

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хууль (МУҮХ)-ийн Хоёрдугаар бүлэг “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хэсэг нь өмнөх үеийн Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэдийн Үндсэн эрх, үүргийн уламжлалыг хадгалахын зэрэгцээ, дараах гурван зарчмын шинэ баримтлал дээр үндэслэсэн болохыг Үндсэн хуулийн эхийг баригч, доктор, профессор Б.Чимид тэмдэглэжээ. Үүнд, 1 дүгээрт монгол төр ба монгол нутагт байгаа хүний асуудал, 2 дугаарт монгол иргэн, монголын харьяат иргэн ба монгол төрийн асуудал, 3 дугаарт төрөөс иргэнийхээ өмнө тэдгээр эрх, эрх чөлөөг хангахтай холбоотойгоор үүргийг хариуцна гэсэн баримтлал хамаарна.<sup>1</sup> Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт хуульчлагдсан “Хүний эрх, эрх чөлөө” хэсэг нь төр, иргэн хоёр харилцан холбоотой, харилцан хариуцлага хүлээдэг арга зүйд суурилсан хэмээн тодорхойлох боломжтой.<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;” хэмээн хуульчилсан.

Энэхүү илтгэлд өгүүлэх “хүрээлэн байгаа орчны эрх<sup>3</sup>” (англи хэл: environmental rights) гэсэн үзэл санааг хүн төрөлхтний түүхэнд хууль эрх зүйн хүрээнд тодорхойлох оролдлого Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-аас эхлэлтэй гэж судлаачид үздэг.<sup>4</sup> Тодруулбал, 1969 онд батлагдсан АНУ-ын Үндэсний хүрээлэн байгаа орчны бодлогын тухай хууль (National Environmental Policy Act)-ийн §4331.(c)-д “АНУ-ын Конгресс нь хүн бүр эрүүл хүрээлэн байгаа орчныг хүртэх ёстой ба хүн бүр тэрхүү хүрээлэн байгаа орчныг хамгаалах, сайжруулахад хувь нэмэр оруулах үүргийг хүлээнэ гэдгийг зөвшөөрнө<sup>5</sup>” гэж хуульчилжээ.

Харин Монгол Улсын хувьд хүрээлэн байгаа орчны эрхийг

<sup>1</sup> Энэ тухай дэлгэрүүлж Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн эхийг баригч, Улаанбаатар, 2010, 74 дэх тал

<sup>2</sup> Мөн тэнд, 95 дахь тал

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад “хүрээлэн байгаа орчин” гэсэн нэр томъёо ашигласан байх тул энэхүү илтгэлд “хүрээлэн буй орчны эрх” бус “хүрээлэн байгаа орчны эрх” гэсэн нэр томъёог ашигласан болно.

<sup>4</sup> 畠山武道『自然保護法講義第2版』(北海道大学出版、2008)36頁。

<sup>5</sup> An official website of the United States Government.42 U.S.C. 4321 et seq. NEPA, <https://www.regulations.gov/document/EPA-HQ-OW-2022-0128-0600> (Сүүлд хандсан 2025.03.11). Мөн зүйлд “(c) The Congress recognizes that each person should enjoy a healthful environment and that each person has a responsibility to contribute to the preservation and enhancement of the environment.” гэж хуульчилжээ.

дээр дурдсанчлан 1992 оны МУҮХ-ийн Арван зургаадугаар зүйлд анхлан хуульчилсан гэж үзэх үндэслэлтэй. Гэсэн хэдий боловч Үндсэн хууль дахь хүрээлэн байгаа орчны эрхийн баталгаа, түүний онцлогийн талаар дэлгэрүүлэн авч үзсэн бүтээл хангалттай хэмжээнд бичигдээгүй байх тул энэхүү илтгэлээр тус асуудлыг тодруулан авч үзэхийг зорилго болгов.

## **II. Үндсэн хэсэг**

### **A. Хүрээлэн байгаа орчин, байгаль орчин зэрэг нэр томьёоны тухай товчхон**

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээнд хүрээлэн байгаа орчны эрх гэсэн нэр томьёо хэрэглэгдээгүй. Харин “хүрээлэн байгаа орчин”, “эрүүл, аюулгүй орчин” болон “байгаль орчин” гэдгийг холбогдох хуулийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт хуульчилсан нь бий.

Тодруулбал, 1995.03.30-ны өдрийн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн<sup>6</sup> 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад «байгаль орчин» гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна;” гэж заажээ.

Харин 2016.02.04-ний өдрийн Эрүүл ахуйн тухай хуулийн<sup>7</sup> 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “хүрээлэн байгаа орчин” гэж хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлөх байгаль, нийгмийн орчныг; 3.1.5 дахь заалтад “эрүүл, аюулгүй орчин” гэж хүрээлэн байгаа орчин эрүүл ахуйн нөхцөл, шаардлага бүрэн хангасан байхыг хэлнэ хэмээн тус тус хуульчилжээ. Гэхдээ энэхүү илтгэлд “хүрээлэн байгаа орчин”, “эрүүл, аюулгүй орчин”, “байгаль орчин” зэрэг хуулийн нэр томьёоны асуудлыг үүгээр хязгаарлаж, “хүрээлэн байгаа орчны эрх” гэсэн нэр томьёог хэрэглэж Монгол Улсын Үндсэн хуульд тус эрхийн баталгааг хэрхэн хуульчилсан онцлогтой болохыг дараах хэсэгт авч үзье.

### **B. Хүрээлэн байгаа орчны эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан нь**

Монгол Улсын Үндсэн хуульд хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг тусгахдаа 1) иргэний үндсэн эрх; 2) иргэний журамт үүрэг; 3) төрийн хүлээх үүрэг гэсэн гурван талаас нь хуульчилсан гэж

<sup>6</sup> Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/8935> (Сүүлд хандсан 2025.03.11).

<sup>7</sup> Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/11635> (Сүүлд хандсан 2025.03.11).

тайлбарлах боломжтой бөгөөд түүний хууль зүйн үндэслэлийг дараах байдлаар тайлбарлах боломжтой. Тодруулбал,

1) **Хүрээлэн байгаа орчны эрх нь иргэний үндсэн эрх болох тухайд:** Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;” гэж заасан. Энэхүү эрх нь Монгол Улсын эрх зүйн хөгжлийн түүхэнд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд анх удаа хуульчлагдсан онцлогтой.<sup>8</sup>

Энэ зүйлд заасан “эрүүл, аюулгүй орчин” гэдэг нь зөвхөн “байгаль орчин” гэх явцуу утгаар хязгаарлагдахгүй хүний “нийгмийн орчин”-г мөн хамааруулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд хүнийг хүрээлсэн цогц нөхцөл гэж тайлбарлагдаж, төрөөс хүний тэрхүү эрхийг баталгаажуулан хэрэгжүүлэх нөхцөлийг хангана<sup>9</sup>.

Мөн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь ангиллын хувьд “нийгэм-соёлын эрх”-ийн агуулгад хамаарах бөгөөд хүн, байгаль, нийгмийн харилцан шүтэлцээнээс үүдэлтэй бөгөөд хүн өөрөө байгалийн амьтан болохын хувьд түүнд цэвэр агаар, цэнгэг ус, цэлмэг тэнгэр, эрүүл хөрс зайлшгүй хэрэгцээтэйгээс гадна хүн энх амгалан, эрүүл саруул орчинд аж төрж болох эсэх нь нийгмийн дэг журам, аюулгүй байдал зэрэг төрийн зүгээс явуулж буй бодлогоос шууд болон дам хамаардаг<sup>10</sup>. Мөн иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх нь хүний амьд явах эрхээ хэрэгжүүлэхэд нягт холбоотой бөгөөд үйлдвэржсэн нийгмийн орчин үеийн хөгжил зэрэгтэй дагалдан зайлшгүй хамгаалах шаардлага үүсэж буй эрх юм<sup>11</sup>.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;” гэсэн нь нэгдүгээрт, хүний эрүүл саруул аж төрөхөд шууд хамааралтай, нэн шаардлагатай орчин, хоёрдугаарт, хүний эрүүл саруул аж төрөхөд шууд хамааралгүй боловч хүний өдөр тутмын амьдралд тохиолдох хүний амьдралын орчин, гуравдугаарт, цэвэр байгаль орчин гэсэн гурван хүрээнд тайлбарлаж болох хүрээлэн

<sup>8</sup> Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй), Улаанбаатар, 1999, 160 дахь тал

<sup>9</sup> Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл, Улаанбаатар, 2004, 20 дахь тал. Мөн энэ тухай, Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар Улаанбаатар, 2022, 189-190 дэх тал

<sup>10</sup> Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, 2008, 122 тал

<sup>11</sup> Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар, 2000, 87-88 дахь тал

байгаа орчныг цогц багтаасан шинжтэй.<sup>12</sup>

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хүрээлэн байгаа орчны эрхийн талаарх үзэл санааг салбар хуульд тухайлбал 1995 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХТХ)-д дэлгэрүүлэн хуульчилсан бөгөөд энэхүү илтгэл салбар хууль дахь холбогдох зүйл, заалтыг дэлгэрүүлэн танилцуулах явдлыг товчилсон болно.<sup>13</sup>

**2) Хүрээлэн буй орчны эрх ба иргэний хүлээх журамт үүрэг:** Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 2 дахь хэсэгт “байгаль орчноо хамгаалах” нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж заасан<sup>14</sup>.

Энэ заалтад заасан “журамт үүрэг” гэдгийг хүн, иргэний хувьд албадлага, шаардлагагүйгээр зүй ёсоор хийх ёстой үйлдлийн нийлбэр цогц гэж тайлбарладаг<sup>15</sup>. Мөн хувь хүн өөрийн гэр орныг органик хэрэгцээ болохын хувьд хайрлан хамгаалж байдагтай адилаар “байгаль орчин бол хүний гэр орны нь гэр орон” байдаг тул түүнийг хайрлан хамгаалах зүй ёсны эрх ашиг, хэрэгцээ байдаг учраас ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд журамт үүрэг гэж тодорхойлжээ.<sup>16</sup>

Харьцуулсан эрх зүйн судлалын үүднээс авч үзэхэд хүрээлэн байгаа орчны эрхийг хүрээлэн байгаа орчныг хамгаалах үүрэг болох

<sup>12</sup> Тухайлбал, Япон Улсын хүрээлэн буй орчны ном бүтээлд “хүрээлэн байгаа орчны эрх”-ийг тайлбарлахдаа тэрхүү “орчин” гэдгийг 生命・健康-Seimei/kenkou- Хүний амьд байх, эрүүл саруул орших, 生活環境-Seikatsu kankyo-Хүнийг хүрээлсэн өдөр тутмын амьдралын орчин, 快適環境-Kaiteki kankyo-Тааламжтай байх орчин, 自然環境-Shizen kankyo-Эх болсон байгаль орчин, 地球環境-Chikyū kankyo-Ертөнц, сансар огторгуйн орчин гэсэн ангилал төрөлжүүлэлтийг дурдсан байдаг. Энэ тухайд, 北村喜介『環境法第2版』(有斐閣、2019)3頁。

<sup>13</sup> Жишээлбэл, тус хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” хэмээн заасан байдаг.

<sup>14</sup> БОХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх”, “байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхдэдээ экологийн хүмүүжил олгох”, “байгаль орчинд хортойгоор нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх”, “байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх” гэж тус тус заасан.

<sup>15</sup> Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, 2008, 102 дахь тал; Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Улаанбаатар, 2022, 308 дахь тал

<sup>16</sup> Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Улаанбаатар, 2022, 318-319 дэх тал

талаас хуульчлах хандлага байдаг. Хүрээлэн байгаа орчны эрхийг хүрээлэн байгаа орчныг хамгаалах үүрэг талаас хуульчлах нь нэг талаас зөвхөн одоо үед оршин буй иргэнд бус ирээдүй хойч үеийн иргэн ч гэсэн эрүүл орчин хүртэх эрхтэй байх гэсэн үзэл санаатай холбоотой. Зөвхөн одоо үеийн иргэд хүрээлэн байгаа орчны эрхийг эдэлнэ гэж үзвэл байгалийн баялгийг хэтрүүлэн ашиглах, хорт бодис, хаягдал зэрэг бохирдуулагч эх үүсвэрийг ихээр гаргах нь ирээдүй хойч үеийн хүрээлэн байгаа орчны эрхийг зөрчиж буй хэрэг хэмээн тайлбарлагддаг.<sup>17</sup> Энэ утгаараа хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг бүрдүүлэхэд хүрээлэн байгаа орчныг хамгаалах үүрэг болох талаас нь хуульчлах шаардлага үүсдэг. Мөн хоёр дахь үндэслэл нь хүрээлэн байгаа орчны эрх нь хэдийгээр хүнд зөвшөөрсөн эрх хэдий боловч хүн төрөлхтөн бусад амьд биетээс давуу эрхтэй оршин амьдрах эрхтэй гэсэн санааг илэрхийлээгүй, харин бусад амьд биет эх дэлхийд мөн адил оршин амьдрах боломж нөхцөлийг үлдээх, түүнийг хангаж өгөх үүргийг хүлээх агуулгыг илэрхийлнэ.<sup>18</sup> Гурав дахь үндэслэл нь хүрээлэн байгаа орчны эрх нь зөвхөн өндөр хөгжилтэй улсын иргэнд хүлээн зөвшөөрсөн эрх биш бөгөөд харин хүрээлэн байгаа орчны нөхцөл тааруу орчинд ажиллаж, амьдарч буй хөгжиж буй орнуудын иргэнд илүү хамгаалагдах ёстой гэж үздэг. Иймд өндөр хөгжилтэй орны иргэдийн зүгээс хөгжиж буй орны иргэдийн хүрээлэн байгаа орчныг сайжруулах, дэмжихэд зүтгэл гаргах үүргийг хүлээнэ гэж тайлбарлагддаг.<sup>19</sup>

Дээрхээс дүгнэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 2 дахь хэсэгт “байгаль орчноо хамгаалах” нь иргэн бүрийн журамт үүрэг гэсний “байгаль орчин” гэдгийг зөвхөн ан амьтан, гол мөрөн, уул ус гэх зэрэг цэвэр байгаль орчны объектоор хязгаарлагдахгүй, хүний эрүүл саруул амьдрах орчин, хүний эргэн тойронд байх амьдралын орчин, эх дэлхийн байгаль орчин гэсэн гурван хүрээг бүхэлд нь хамаарч ойлгох нь зүйтэй. Ингэхдээ байгаль орчныг хамгаалах үүрэг нь одоо үеийн иргэдээс ирээдүй хойч үеийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг хангахад нэн шаардлагатай, түүнчлэн эх дэлхий дэх бусад амьд биетийн оршин амьдрах боломж нөхцөлийг үлдээх, хамгаалахад чиглэсэн үүрэг хэмээн тайлбарлан ойлгох боломжтой.

**3) Хүрээлэн буй орчны эрхийн баталгаа ба төрийн үүрэг:** Монгол Улсын Үндсэн хуульд хүрээлэн буй орчны эрхийн баталгааг төрийн хүлээх үүрэгтэй холбоотой тайлбарлаж болох үндэслэлийг а) Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйл, б) Арван есдүгээр

<sup>17</sup> 畠山武道『自然保護法講義第2版』(北海道大学出版、2008)42頁。

<sup>18</sup> Мөн тэнд, 43 дахь тал

<sup>19</sup> Мөн тэнд, 43 дахь тал

зүйлийн 1 дэх хэсэг, в) Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад тус тус хуульчилсан. Тодруулбал,

**а) Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн тайлбар:** Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж тус тус заасан.

Дээрх зүйлд заасны дагуу газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү “ард түмний мэдэлд” байна гэдгийг түүнийг ямар нэг этгээд, ялангуяа төр ч туйлын утгаар “өмчлөхгүй” гагцхүү нийтийн баялаг байна, харин төр тусгай дэг журмын дагуу ард түмний өмнөөс хязгаарлагдмал эрх хэрэгжүүлнэ гэж тайлбарладаг.<sup>20</sup> Мөн энэ зүйл заалттай холбоотойгоор Б.Чимид “... Төрийн хамгаалалтад байх, төр өмчтэй байх хоёр бол их, бага хоёр ухагдахуун. Монгол Улсын газар бүхэлдээ төрийн хамгаалалтад байна. Ард түмний сувернитэд байна. Тусгаар тогтнолтой холбоотой асуудал.”<sup>21</sup> хэмээн тэмдэглэж байжээ.

Мөн доктор, профессор Г.Совд бүтээлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд байгалийн баялаг, нөөцөө тухайн улс үндэстэн өөрсдийнхөө ашиг сонирхол, хэрэгцээнд зориулан чөлөөтэй эзэмшиж, ашиглах эрхийг хуульчилсан чухал баталгаа мөн бөгөөд энэ нь Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг бий болгох чухал нөхцөл хэмээн тодорхойлжээ.<sup>22</sup>

Дээрх Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл заалт нь 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль (1924 оны Монгол Улсын Үндсэн хууль), 1940 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль (1940 оны Монгол Улсын Үндсэн хууль), 1960 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль (1960 оны Монгол Улсын Үндсэн хууль)-д заасан уламжлалыг хадгалсан шинжтэй гэж үзэж болно.<sup>23</sup> Тодруулбал, дараах хүснэгтэд

<sup>20</sup> Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Улаанбаатар, 2022, 81 дэх тал

<sup>21</sup> Энэ тухай дэлгэрүүлж Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн эхийг баригч, Улаанбаатар, 2010, 164 дэх тал

<sup>22</sup> Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй), Улаанбаатар, 1999, 23-24 дэх тал

<sup>23</sup> Гэхдээ 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль болон өмнөх үеийн Үндсэн хуульд тус харилцааг зохицуулсан зүйл заалтын бодит хэрэгжилт харилцан зөрүүтэй байсныг үгүйсгэхгүй юм. Энэ тухай Доктор, профессор Г.Совд бүтээлдээ “1992 оны Үндсэн хуулиас өмнө үйлчилж байсан Монгол Улсын Үндсэн хуулиудад үндэсний

1924 оны Монгол Улсын Үндсэн хууль, 1940 оны Монгол Улсын Үндсэн хууль, 1960 оны Монгол Улсын Үндсэн хууль дахь холбогдох зүйл заалтыг түүвэрлэж харьцуулсан болно.

*Хүснэгт 1. 1924, 1940, 1960 оны Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтын харьцуулалт*

1924 оны МУҮХ	1940 оны МУҮХ	1960 оны МУҮХ
<p><b>Гуравдугаар зүйл</b> НЭГ. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно.</p>	<p><b>Тавдугаар зүйл</b> Бүх газар шороо ба түүний хөрсөн доорх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, завод, фабрик, төмөр л ө г и й н уурхай, алт б о л о в с р у л а х явдал, төмөр, авто тээврийн зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд нь улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно.</p>	<p><b>Аравдугаар зүйл</b> Бүх газар, түүний хөрсөн доорх баялаг, ой мод, гол ус, тэдгээрийн баялаг, улсын фабрик, завод, уурхай, цахилгаан станц, төмөр зам, авто машин, усан ба агаарын тээвэр, засмал зам, холбооны хэрэгсэл, банк, улсын хөдөө аж ахуйн үйлдвэрийн газар (сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станц зэрэг), улсын нийгэм ахуйн газар, хот, суурин газрын орон сууцны улсын үндсэн фонд, улсын үйлдвэрүүдийн түүхий эд, материал, бүтээгдэхүүн, улсын худалдаа бэлтгэлийн ба соёл, шинжлэх ухааны газрууд, мөн улсын бүх байгууллагын эд хөрөнгө, энэ бүхэн бол улсын өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө юм.</p>

*баялаг нь нийт ард түмний мэдэлд байхаар зарлан тунхаглаж байсан боловч тэр нь амьдралд хэрэгжих баталгаагүй хэлбэрийн төдий бичээс болж байлаа” хэмээн бичжээ. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй), Улаанбаатар, 1999, 23 дахь тал*

	<p><b>Тавдугаар зүйл</b> Улсын дээд эрхийг хадгалах газруудын эрхлэн шийтгэвэл зохих зүйлүүд нь: Арав. Газар эдлэх нийтийн дүрмийг батлах, аймаг хошуудын нутгийн хил хязгаарыг байгуулах, дэлхийн баялгийг ашиглах дүрэм заавар тогтоох;</p>	<p><b>Наймдугаар зүйл</b> Газар бол улсын өмч буюу нийт ардын хөрөнгө болох тул ард иргэн ба хөдөлмөрчдийн сайн дурын нэгдлүүдэд бэлчээр буюу тариалангийн газрыг үнэ төлбөргүйгээр олгоно.</p>	<p>-</p>
	<p>-</p>	<p><b>Аравдугаар зүйл</b> Бүгд Найрамдах Монгол Ард Улсын өмнөөс засгийн дээд эрх барих ба улсын захиргааны дээд газруудын эрхлэх хэрэг нь: 17.Тус улсын байгалийн баялгийг хамгаалах ба ашиглах, газар шороо, ой мод, ус билчээр ба түүний баялгийг ашиглах журмыг тогтоох;</p>	<p>-</p>

*Эх сурвалж:* 1924 оны Монгол Улсын Үндсэн хууль, 1940 оны Монгол Улсын Үндсэн хууль, 1960 оны Монгол Улсын Үндсэн хууль дахь холбогдох зүйл заалтыг түүвэрлэж зохиогч боловсруулсан болно.

Дээрхээс үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан өмнөх үеийн Үндсэн хуульд заасан уламжлалыг хадгалсан шинжтэй зохицуулалт хэмээн дүгнэхээр байна.

**б) Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн тайлбар:** Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр

зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Төрөөс иргэдийн эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх, соёл боловсрол, урлаг, спорт жуулчлалыг хөгжүүлэх, эрүүл ахуй, нийгмийн хангамж, хамгаалалт, орон сууц зэрэг аж амьдралын амин чухал асуудлыг нийгмийн бодлогынхоо дээд хууль болгосноор хүний эрхийн нийгмийн баталгааг хангана<sup>24</sup>. Энэ зүйл бүхэлдээ хүний эрх, эрх чөлөөг хангах талаар төрийн чиг үүргийг тунхаглан тодорхойлсон.

Б.Чимид бүтээлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлд 18 дэд зүйлээр бататгасан эрх, эрх чөлөө нь “Төр” хэмээх “өгөөмөр” хүчнээс “хүн” гэдэг “ядмаг амьтан”-д хишиг хүртээж буй утгаар бус, хүнд өөрт нь хийгээд ардчилсан нийгэмд байдаг эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн хэрэг бөгөөд түүнийг хангах баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцах тухайд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэмээн тайлбарлажээ.<sup>25</sup>

Энэ утгаараа Үндсэн хууль дахь хүрээлэн байгаа орчны эрх, тухайлбал өмнөх хэсэгт дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;” гэсэн заалтыг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцна хэмээн тайлбарлах боломжтой.

**в) Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын тайлбар:** Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан. Энэхүү заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг хангахын тулд төр үүрэг хүлээдэг болохыг илэрхийлж байгаа хэрэг хэмээн тайлбарлагддаг.<sup>26</sup>

<sup>24</sup> Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар, 2000, 134-135 дахь тал

<sup>25</sup> Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл, Улаанбаатар, 2004, 17 дахь тал; Мөн энэ тухай, Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, Улаанбаатар, 2022, 334-335 дахь талыг үзнэ үү.

<sup>26</sup> Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар, 2000, 189 дэх тал

Мөн энэ зүйлд заасан “хүрээлэн байгаа орчин” гэдэг нэр томъёололтой холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх үед Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын 1991.12.12-ний өдрийн 30 дугаар протоколд У.Мавлет (81 дүгээр тойргийн депутат) хэлэхдээ

*“... Хэрэв бид яг байгаль хамгаалах гэвэл бид чинь гурван орчинд амьдарч байгаа шүү дээ. Тэгэхээр агаар мандлыг чинь хэн хамгаалах юм бэ?, Газрын дор байгаа энэ ашигт малтмалыг чинь хэн хамгаалах юм бэ?, ер нь энд тэр байгаль хамгаалах гэдгийг ингээд орхивол энд байгаа нөгөө хэдэн зээрээ л эргэж ярина. Хэдэн тарвагаа л ярина. Өөр юм ярихгүй. Тийм учраас заавал хүрээлэн байгаа гэдэг асуудлыг оруулжээ. ...”<sup>27</sup>* гэжээ.

Дээрхээс дүгнэвэл энэ зүйл заалт нь дан ганцхан “байгаль хамгаалал” гэсэн утгаар бус хүний амьдрах орчинг бүхэлд нь хамааруулсан өргөн ойлголт мөн гэж тодорхойлох боломжтой.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл санааг хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хуулиар дэлгэрүүлэн хуульчилдаг бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тухай (1993) хуулийн 11 дүгээр зүйлд хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаарх Засгийн газрын бүрэн эрхийг тусгайлан заасан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

### III. Дүгнэлт

Энэхүү илтгэлд хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд 1) иргэний үндсэн эрх; 2) иргэний журамт үүрэг; 3) төрийн хүлээх үүрэг гэсэн гурван талаас нь хуульчилсан онцлогтой болохыг тодруулсан болно. Энд товч харьцуулалт дурдвал Япон Улсын Парламентын Номын сангаас “Хүрээлэн байгаа орчны эрхийн талаарх онол” хэмээх лавлагаанд дэлхийн 50-н улсын Үндсэн хуульд хийсэн судалгааны дүнд хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг бүрдүүлэх дараах төрөл байна гэсэн дүгнэлт хийсэн байна.<sup>28</sup> Тухайлбал,

- Хүрээлэн байгаа орчны эрх, улсын хүлээх үүрэг, иргэний хүлээх үүрэг гэсэн гурвал төрөлд хамаарах байдлаар Үндсэн хуульд баталгаажуулсан 17 улс (Азербайжан, Аргентин, Армен, Этиоп, Гүрж, Испани, Словак, Словени, БНСУ, Турк, Финланд, Франц, Болгар,

<sup>27</sup> Энэ тухайд, Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн эхийг баригч, Улаанбаатар, 2010, 283-талаас дэлгэрүүлж үзнэ үү.

<sup>28</sup> 那須俊貴 [著] 国立国会図書館調査及び立法考査局 2007.3 シリーズ憲法の論点, 14. 調査資料|チヨウサ シリョウ; 2006-2-b.Энэхүү судалгааг япон хэл дээр дараах холбоосоор үзнэ үү. [https://dl.ndl.go.jp/view/download/digidepo\\_1001031\\_no\\_200703.pdf?contentNo=1](https://dl.ndl.go.jp/view/download/digidepo_1001031_no_200703.pdf?contentNo=1) (Сүлд хандсан, 2025.03.10).

Польш, Португал, Румын, Орос)

- Улсын хүлээх үүрэг болон иргэний хүлээх үүрэг гэсэн хоёр төрөлд Үндсэн хуульд баталгаажуулсан 7 улс (Энэтхэг, Узбекистан, Гана, Казахстан, Куба, Швейцар, Литва)

- Хүрээлэн байгаа орчны эрх болон иргэний хүлээх үүрэг гэсэн хоёр төрөлд Үндсэн хуульд баталгаажуулсан 1 улс (Чех)

- Хүрээлэн байгаа орчны эрх болон улсын хүлээх үүрэг гэсэн хоёр төрөлд Үндсэн хуульд баталгаажуулсан 5 улс (Албани, Грек, Норвеги, Унгар, Латви)

- Зөвхөн хүрээлэн байгаа орчны эрх болох талаас Үндсэн хуульд баталгаажуулсан 1 улс (Бельги)

- Зөвхөн улсын хүлээх үүрэг болох талаас төрөлд Үндсэн хуульд баталгаажуулсан 7 улс (Афганистан, Алжир, Нидерланд, Камбож, Швед, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Герман)

- Зөвхөн иргэний хүлээх үүрэг болох талаас нь Үндсэн хуульд баталгаажуулсан 1 улс (Эстони) байна гэсэн дүнд хүрсэн байна.

Дээрхээс дүгнэвэл Монгол Улсын Үндсэн хуульд хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг 1) иргэний үндсэн эрх; 2) иргэний журамт үүрэг; 3) төрийн хүлээх үүрэг гэсэн гурван талаас нь хуульчилсан хэмээн тайлбарлах нь харьцуулсан эрх зүйн судлалын үүднээс авч үзэхэд хүрээлэн байгаа орчны эрхийг дээрх гурван төрөлд хамаарах байдлаар Үндсэн хуульд баталгаажуулах нь бусад улсын хууль тогтоомжид байдаг хандлагад нийцсэн хэрэг хэмээн дүгнэхээр байна.

Энэхүү илтгэлд нарийвчлан судлаагүй боловч Үндсэн хууль дахь хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг хангах арга хэлбэрийн нэг нь тус эрхийг процессын шинжтэй эрх болох баталгааг бүрдүүлсний үндсэн дээр бодитоор хамгаалах боломжтой гэсэн орчин үеийн хандлага байгаа талаар тэмдэглэх нь зүйтэй. Үүнийг англи хэл дээрх ном бүтээлд “procedural environmental rights” хэмээн тэмдэглэдэг. Хүрээлэн байгаа орчны эрхийг процессын шинжтэй эрх болох талаас нь баталгааг бүрдүүлэх гэдэг нь мэдээллийн ил тод байдал болон иргэний оролцоог дамжуулан хүрээлэн байгаа орчинд хамаарах захиргааны шийдвэр, үйл ажиллагаанд иргэний саналыг тусгах замаар, үр дүнд нь хүрээлэн байгаа орчны эрх бодитоор хамгаалагдах баталгаа бүрдэнэ гэсэн үзэл санаа юм.<sup>29</sup> Олон улсын эрх зүйн гол эх сурвалж нь

---

<sup>29</sup> Энэ тухайд англи хэл дээр “procedural environmental rights” гэсэн түлхүүр үгээр хайлт хийн эх сурвалж олох боломжтой. Харин япон хэл дээр 手続的環境権 гэсэн түлхүүр үгээр хайлт хийх нь оновчтой. Жишээлбэл, Jendrośka, Jerzy, and Magdalena Bar. “Procedural environmental rights: principle X in theory and practice.” (*No Title*) (2017). Бүтээлийг дараах холбоосоор үзэх боломжтой. [https://www.eelf.info/tl\\_files/uploads/EELF%20Books/Procedural%20Environmental%20rights\\_DEF3.pdf](https://www.eelf.info/tl_files/uploads/EELF%20Books/Procedural%20Environmental%20rights_DEF3.pdf)

1998 оны “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх Аархусын конвенц” (UNECE Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters) бөгөөд Монгол Улсын хувьд тус конвенцэд нэгдэж ороогүй байгаа билээ. Гэхдээ Монгол Улсын хувьд 2009 оны үед тус тус конвенцэд нэгдэн ороход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан гэж үзэх үндэслэлтэй.<sup>30</sup>

Харин 2019.11.14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тус зүйлд “*Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.*” гэж оруулсан нь дээр дурдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2-т заасан “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэдэгтэй салшгүй холбоотой бөгөөд хүрээлэн байгаа орчны эрхийг процессын шинжтэй эрх болох талаас Үндсэн хуульд тусгасан хэмээн тайлбарлах боломж бүрдсэн.

Төгсгөлд нь энэхүү илтгэлийн оршил хэсэгт тэмдэглэсэнчлэн 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хэсэг нь төр, иргэн хоёр харилцан холбоотой, харилцан хариуцлага хүлээдэг арга зүйд суурилсан хэмээн тодорхойлж болох бөгөөд энэ утгаараа хүрээлэн байгаа орчны эрхийн баталгааг Монгол Улсын Үндсэн хуульд хуульчлахдаа 1) иргэний үндсэн эрх хийгээд журамт үүрэг болон төрийн хүлээх үүрэг гэсэн харилцан хамааралтайгаар хуульчилсан онцлогтой хэмээн дүгнэхээр байна.

---

<sup>30</sup> Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2009.05.14-ний өдрийн 38 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 75 дахь хэсэгт “Байгаль орчны талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны аудитын тогтолцоог шинээр бий болгох, иргэдэд байгаль орчны асуудлаар маргаан гарвал шүүхэд хандах эрхийг бий болгох” хүрээнд Монгол Улс “Аархус-Конвенци” /Aarhus-Convention/ –д нэгдэн орох тухай заасан. Дэлгэрүүлж үзэх холбоос, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6997> (Сүүлд хандсан 2025.03.11).

**[Ном зүй]**

Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, 2008

Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл, Улаанбаатар, 2004

Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (Харьцуулсан эрх зүй) Улаанбаатар, 1999

Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар, 2000

Ж.Амарсанаа, Үндсэн хуулийн эхийг баригч, Улаанбаатар, 2010

Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар Улаанбаатар, 2022

An official website of the United States Government.42 U.S.C. 4321 et seq. NEPA, <https://www.regulations.gov/document/EPA-HQ-OW-2022-0128-0600> (Сүүлд хандсан 2025.03.11).

那須俊貴 [著] 国立国会図書館調査及び立法考査局 2007.3 シリーズ憲法の論点, 14. 調査資料|チヨウサ シリョウ ; 2006-2-b. [https://dl.ndl.go.jp/view/download/digidepo\\_1001031\\_po\\_200703.pdf?contentNo=1](https://dl.ndl.go.jp/view/download/digidepo_1001031_po_200703.pdf?contentNo=1) (Сүүлд хандсан, 2025.03.11).

島山武道『自然保護法講義第2版』(北海道大学出版、2008)

北村喜介『環境法第2版』(有斐閣、2019)

**[Abstract]**

**Guarantees of Environmental Rights in The  
Constitution and Their Characteristics**

**Sukhchuluun Sukhbaatar**

*Doctor of Laws (LL.D.).*

*Senior Lecturer at the Public Law Department,  
School of Law, National University of Mongolia*

*Ulaanbaatar, Mongolia*

This article will clarify the relevant provisions of the Mongolian Constitution, adopted on January 16, 1992, that guarantee environmental rights, and will then elaborate on the specifics of these rights as reflected in the Constitution. For example, this article explains that the Mongolian Constitution, in guaranteeing environmental rights, addresses three legal aspects: 1) the fundamental rights of citizens; 2) the sacred obligations of citizens; and 3) the obligations of the state. Additionally, the aspect of ensuring environmental rights as a procedural right was introduced through the amendments to the Constitution of Mongolia, adopted on November 14, 2019.

**[Keywords]**

Environment, Nature Environment, Healthy and Safe Environment.